

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН¹

*Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл боловсруулах тухай*

Ерөнхий мэдээлэл:

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлэх², эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйн салбарын шинэчлэлийг үр дүнтэйгээр зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргаж, бизнест ээлтэй орчныг бүрдүүлэх, төлбөр тооцоо, бүртгэлийн бүх үйл ажиллагааг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хийж гүйцэтгэх орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хурлаар батлуулж хүчин төгөлдөр мөрдөж байна.

Уг хуулийн төслийг боловсруулахдаа 2003 онд батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг олон улсын өнөөгийн болон цаашдын чиг хандлагад нийцүүлэн хуулийн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх, бүртгэлийн цахим мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх, иргэн, хуулийн этгээдэд цахимаар бүртгүүлэх боломжийг бүрдүүлэх, бүртгэл хийх цаг хугацааг хэмнэх замаар бүртгэлийн байгууллага, ажилтанд ирэх ажлын ачаалал, зардлыг багасгах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарч холбогдох зохицуулалтуудыг хийсэн байна.

Мөн хуулиар хуулийн этгээдийг бүртгүүлэхийн тулд 12 төрлийн бичиг баримт бүрдүүлж 8 шат дамжлагаар 5 хоногт бүртгүүлж байсныг хялбаршуулж, хуулийн этгээдийг бүртгүүлэхэд бүрдүүлэх бичиг баримтыг цөөрүүлж, бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай болгох, бүртгэлийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох, хуулийн этгээдийн улсын бүртгэл болон хувийн хэрэг хөтлөх, лавлагаа олгохтой холбогдон үүсэх харилцааг цогц байдлаар зохицуулахаар тусгажээ.

Шинэчилсэн найруулгын хүрээнд дээр дурдсан зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүдийг оруулсан хэдий ч нийгмийн харилцааны хөгжил, түргэн өөрчлөгдөж буй улс орны нийгэм, эдийн засгийн байдалтай уялдуулан хууль, эрх зүйн хүрээнд дахин нягталж зохицуулах шаардлагатай тодорхой асуудлууд байна.

¹ Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.

² Монгол Улсын Үндсэн хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

Хэдийгээр хуульчдын зүгээс хуульд өөрчлөлт оруулах давтамж, хугацааг хууль тогтвортой үйлчилж байх зарчмын үүднээс шүүмжлэх хандлага байдаг ч хуулийн хэрэгжилт, үр нөлөөг нэмэгдүүлэх, алдаа дутагдлыг засаж сайжруулах, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулиас дээгүүр болзол шаардлагыг дүрэм, журмаар тогтоохоос татгалзаж, бүртгэлийн суурь харилцааг хуулийн хүрээнд илүү тодорхой, нийтэд ойлгомжтой байдлаар зохицуулах хэрэгцээ, шаардлага байгаа юм.

Иймд Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Засаглалын бодлого хэмээх Тавдугаар бүлгийн 5.2.8-д “Улсын бүртгэлийн ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.” гэж, 5.2.11-д “Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах” гэж, мөн Улсын Их Хурлын баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловронгуй болгох үндсэн чиглэл”-д Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг шинэчлэн найруулах гэж заасны дагуу холбогдох хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын³ /цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан үе шатын дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.Манай орны хувьд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай анхны хууль 2003 онд батлагдсанаас хойш нийт 9 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, 2015 онд шинэчилсэн найруулгын төслийг баталсан юм. Уг хууль нь 8 бүлэг, 28 зүйлтэй бөгөөд Монгол Улсад хуулийн этгээд шинээр үүсэн байгуулагдсан, өөрчлөн байгуулагдсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бичгээр болон цахим хэлбэрээр бүртгэх, иргэн, хуулийн этгээдэд лавлагаа олгох, улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.⁴

Энэхүү хууль хэрэгжээд удаагүй байгаа боловч зарим зохицуулалтыг дахин нягталж боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх, Иргэний хууль болон Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зүй ёсны шаардлага тавигдаж байна.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож,

³Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

⁴Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 8 дугаарт нийтлэгдсэн

тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зохицуулалтыг Иргэний хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлж улсын бүртгэлийн байгууллагаас бүртгэх хуулийн этгээдийн төрлийг шинэчлэн тогтоож, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуультай уялдуулан зарим нэмэлт, өөрчлөлтийг тусгах замаар хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;

2. Хууль зүйн сайдын 2015 оны А/39 тоот тушаалаар баталсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”, А/40 тоот тушаалаар баталсан “Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам”, А/41 тоот “Хуулийн этгээдийн нэр олгох баталгаажуулах журам”, А/42 тоот тушаалаар баталсан “Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”, 335 тоот тушаалаар баталсан “Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх журам”-аар тогтоож байгаа бүртгэлийн зарим суурь харилцааг хуулийн хүрээнд илүү тодорхой байдлаар зохицуулах;

3. Хууль хэрэгжих хугацаанд практикт үүсээд буй тодорхой асуудлуудыг шийдвэрлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэл хийхэд эрх зүйн зохицуулалтгүй байдлаас үүдэн иргэд, бүртгэлийн байгууллагад үүсдэг бэрхшээлүүдийг даван туулах, улсын бүртгэлийн байгууллагын зарим чиг үүргийг нийтэд ойлгомжтой болгох зорилгоор холбогдох өөрчлөлтүүдийг хийх;

4. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг илүү төрөлжсөн хуулийн хүрээнд буюу Улсын Их Хурлаас баталсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Энэ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 01 сарын 27-ны өдрийн А/16 тоот тушаалаар байгуулсан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн хурлаас гишүүдийн гаргасан санал, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн санал, холбогдох тооцоо, судалгаа, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн судалгаа, дүгнэлт, зөвлөмж зэргийг судалж үзсэн болно.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:

Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрлийн хүрээнд бүртгэл хөтлөх, хувийн хэргийг бүрдүүлэх, иргэн, хуулийн этгээд болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэл, лавлагаа өгөх, шинээр үүсэн байгуулагдсан, өөрчлөн байгуулагдсан, татан буулгасныг болон холбогдох мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх талаар бүртгэлийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар тогтоодог.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар тус хуулийн хүрээнд эрх ашиг нь хөндөгдөж байгаа хуулийн этгээдийн (улсын хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 169662 буюу нийслэлд 132704, орон нутагт 36958 хуулийн этгээд бүртгэлтэй байна)⁵ хувьд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэхгүй бөгөөд харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмж нэмэгдэж, бүртгэлийн байгууллагад хандан үйлчлүүлж байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нөхцөл сайжирна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

Холбогдох мэдээллийг харьцуулан дүгнэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад маргаантай, шийдвэл зохих дараахь асуудлууд байсаар байна.

1. Иргэний хуулийн 25.2-д “Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно.”, 33.1-д “Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна.”, 33.2-д “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.” гэж хуулийн этгээдийн төрлийг, мөн 26.1-д “Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.” гэж хуульчилсан байдаг.⁶

Гэтэл Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд холбоо, санг бүртгэх эсэх талаар хэрхэн зохицуулж байгаа нь тодорхойгүй, түүнчлэн хэвлэл мэдээлэл, соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн зэрэг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрлийг үүсгэж улсын бүртгэлд бүртгэхээр тусгажээ. Эдгээр нь Иргэний хуулиар тогтоосон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн холбоо, сан, хоршооны хэлбэрийн аль төрөлд хамаарах нь тодорхойгүй байгаа юм.

2. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш практикт үүсээд буй бэрхшээлүүд, тухайлбал, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11.3-д хуулийн этгээд нь өөрийн хувийн хэргийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг ажлын 15 хоногийн дотор улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэхээр заасан бөгөөд эрх бүхий төрийн байгууллагаас зөвшөөрөл авдаг өөрчлөлтийн хувьд хуулийн этгээд нь энэ хугацаанд өөрчлөлтөө бүртгүүлж амжихгүй байх тохиолдол үүсдэг.

3. Эрх зүйн зохицуулалтгүй байдлаас шалтгаалж иргэдэд ойлгомжгүй, хэрхэн шийдвэрлэх нь маргаантай нөхцөл байдал үүсэх тохиолдлууд олон байна. Жишээ нь, хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд тамга, тэмдэг, баталгааны хяналтын дугаарыг олгодог. Гэтэл хуулиар тамга, тэмдгийн хяналтын дугаарыг шинээр олгох, өмнөх тамга, тэмдэг /гэрчилгээний дугаар, тамга, тэмдгийн хяналтын дугаар/-ийг хүчингүйд тооцох талаар зохицуулалт байхгүйгээс хувьцаа эзэмшигчид буюу үүсгэн байгуулагчдын хооронд шийдвэрлэхэд хүндрэлтэй маргаан байсаар байна.

⁵ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээлэл, 2017 он

⁶ Иргэний хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн

Мөн хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах зохицуулалтыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулж байгаа хэдий ч хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газарт нэр олгох, хуулийн этгээдийн нэрийн өмнө болон хойно нь тоогоор болон дан тоогоор баталгаажуулалт хийх эсэх талаар болон хуулийн этгээд татан буугдсан, оноосон нэрээ өөрчилсөнийг улсын бүртгэлд бүртгүүлэх хугацааны талаарх зохицуулалт байхгүй байна.

Тухайлбал, бүртгэлийн байгууллагаас гаргасан тоон мэдээллээр 2016 оны жилийн эцсийн байдлаар 1968 салбар, төлөөлөгчийн газар бүртгэлтэй байгаагаас шинээр 207 салбар бүртгэгдэж, хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар бүртгэгдээгүй гэсэн судалгаа байгаа бөгөөд нэр олгох талаар зохицуулалт байхгүйгээс ойлгомжгүй байдал үүсдэг байна.⁷

Түүнчлэн тус хуульд өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг, мөн хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх талаарх зохицуулалтыг тусгасан хэдий ч цогц байдлаар хуульчлаагүй, зарим төрлийн суурь харилцааг салбарын хүрээний дүрэм, журмаар зохицуулж байгаа нь иргэд бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлэхдээ баримт бичгийн бүрдлээ дутуу хангах, дахин дахин ирж буцах зэргээр чирэгдэл үүсэх тохиолдлууд байна.

Үүнээс дүгнэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг цаашид боловсронгуй болгох, үзэл баримтлалаа тууштай тогтоож хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараахь байдлаар тодорхойлж байна.

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, үйл ажиллагааны түргэн шуурхай, чирэгдэлгүй байдлыг нэмэгдүүлэх замаар практикт үүсэж буй тодорхой асуудлуудыг шийдвэрлэх, хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгахад оршино.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Хуулийн этгээдийн улсын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн учлдаа холбоог хангах” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараахь дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг

⁷ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээлэл, 2017 он

2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилахгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй .	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг эдийн засгийн арга хэрэгслээр зохицуулах боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй .	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллагыг чадавхижуулах, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэснээр зарим талаар байгууллагын үйл ажиллагааг дэмжих хэдий ч зорилгыг хангаж чадахгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй .	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
5	Захиргааны шийдвэр гаргах	Бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг баталж тодорхой асуудлуудыг шийдвэрлэж болох хэдий ч хууль хоорондын уялдаа холбоог хангахгүй. Иргэдийн эрх ашгийг бүрэн хамгаалж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй .	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Өнөөгийн бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенци хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон хуулийн нийт зүйл, заалтын талаас илүү хувьд нэмэлт, өөрчлөлт орж болзошгүйг харгалзан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухайн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Уг шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахтай уялдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Түргэн шуурхай, илүү ойлгомжтой бүртгэлийн үйлчилгээг иргэдэд санал болгох замаар Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эрх зүйн зохицуулалтын хувьд зарим төрлийн харилцааг хуулиар зохицуулаагүй хэдий ч бүртгэлийн байгууллагын практикт хийгддэг ажиллагаа учраас Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд өөрчлөлт оруулснаар эдийн засагт ачаалал үүсгэхгүй бөгөөд байгууллагын дотоод үйл ажиллагааны хүрээнд зохицуулалт хийх байдлаар асуудлыг шийдвэрлэх боломжтой.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор иргэд өдөр тутам бүртгэлийн байгууллагаас түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ авна.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.” гэж, Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д “Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно.”, 25.5-д “Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.”, 26.2-д “Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан тул хууль боловсруулахаар сонгосон хувилбар нь Үндсэн хуулийн зарчим болон Иргэний хуулийн агуулга, үзэл баримтлалтай нийцэж байна.

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;

- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараахь дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Олон улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулан дүгнэхэд дурдсан асуудлуудыг хууль боловсруулах замаар шийдвэрхлэх боломжтой юм.

ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Бусад орны бүртгэлийн систем, хуулийн этгээдийн бүртгэлийн төрөл, хэрэгжүүлэх байгууллагын чиг үүрэг зэрэг чиглэлээр хийгдсэн судалгааны мэдээлэлд үндэслэн зарим асуудлыг тодруулах зорилгоор БНСУ, ХБНГУ-ыг сонгож авлаа.

Бүгд Найрамдах Солонгос Улсын бүртгэлийн тогтолцоо нь Ази, Европын улсуудаас эрс онцлог ялгаатай.⁸ Бүртгэлийн тогтолцоо нь Иргэний бүртгэлийн тухай хууль, Худалдааны бүртгэлийн тухай хуулиудаар зохицуулагдах бөгөөд төрлийн хувьд иргэний болон хуулийн этгээдийн, гэр бүлийн, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл гэх мэт байна. Бүртгэлийн чиг үүргийг хоёр байгууллага хэрэгжүүлэх бөгөөд иргэний бүртгэлийг тус улсын Улсын аюулгүй байдал болон захиргааны яам хариуцдаг бол иргэний бүртгэлээс бусад бүртгэлийг шүүх байгууллага хариуцдаг онцлогтой.

Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай тусгайлсан хуультай бөгөөд хуулийн этгээдийн бүртгэлд дараахь бүртгэл хамаардаг байна:

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани;
- Хувьцаат компани;
- Хамтын бус хөрөнгө оруулалттай нөхөрлөл;
- Хамтын хөрөнгө оруулалттай нөхөрлөл;
- Гадаадын хуулийн этгээд;
- Хувиараа бизнес эрхлэгч; Эрх зүйн чадамжгүй болон эрх зүйн зарим чадамжаа шүүхээр хязгаарлуулсан этгээдийн хувьд хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийн дагуу өөрсдөө болон асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь худалдааны чиглэлийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон бүртгэл.

Улсын бүртгэлийн системийг бүрэн автоматжуулах төслөөр бүртгэлийн тогтолцоо болон бүртгэх процедур нь бүрэн автоматжсан буюу цаасан бүртгэлээс мэдээлэл санах төхөөрөмж рүү шилжсэн. Өөрөөр хэлбэл бүртгэл болон түүнтэй холбогдолтой мэдээллийг хадгалах үйл ажиллагаа цаасан бүртгэлээс цахим бүртгэлд шилжсэн.

Хэрхэн бүртгэх вэ?: Бүртгэлийн газрын голлох чиг үүрэг нь бүртгүүлэх хүсэлтийг хүлээж авах, иргэдийн хүсэлтийн дагуу гэрчилгээ болон түүний хуулбарыг олгох юм.

Түүнчлэн хуулийн этгээдийн гэрчилгээн дэх хувийн тамга тэмдгийг баталгаажуулах, хувийн бичиг баримт дээр нь гэрчилгээ олгосон он, сар, өдрийг тэмдэглэх үүрэгтэй. Өргөдөл хүлээж авах процесс: Бүртгэх үйл ажиллагааг бүртгэлийн маягтыг бөглөснөөр эхэлдэг. Энэхүү маягтыг хууль дүрмийн дагуу бөглөсөн гэж үзвэл

⁸ Бүртгэлийн тогтолцоо:Сайн туршлага, ХЗҮХ, 2014 он

бүртгэлийн асуудал хариуцсан ажилтан бүртгэлийн ажиллагааг дараахь үе шаттайгаар явуулна:

- 1.Өргөдлийг хүлээж авах;
- 2.Хянан шалгах;
- 3.Бүртгэлд оруулах эсэхийг шийдвэрлэх;
- 4.Цахим баталгаажуулалт хийх.

Эдгээр үйл ажиллагаа бүрэн явагдсан бол “бүртгэх ажиллагаа дууссан” гэж үзэж доорх захиргааны ажиллагааг гүйцэтгэдэг байна:

- Бүртгэлийн ажиллагааг дууссаны дараа гэрчилгээ олгох;
- Гэрчилгээг цахим санд бүртгэснээр бүртгэлийн ажиллагаа бүрэн дуусна.

ХБНГУ-ын бүртгэлийн тогтолцоо

Герман Улс нь бусад улсын адил иргэний (төрсөн, нас барсан, гэрлэсэн г.м), хуулийн этгээдийн, газрын, татварын, үл хөдлөх хөрөнгийн, гэмт хэргийн, худалдааны тэмдгийн зэрэг олон төрлийн төрөлжсөн бүртгэлтэй байна. Эдгээр бүртгэлийг тус тусын хуулиудаар зохицуулж, харьяалах төрийн байгууллагууд бүртгэж байна.

Гэхдээ эдгээрээс хуулийн этгээдийн бүртгэлийг тус улсын шүүх хариуцдаг. Хуулийн этгээд нь үйл ажиллагаа эхлэхдээ харьяа орон нутгийн шүүх болон дээд шүүхэд бүртгүүлж, зөвшөөрөл авна. Үндсэндээ хуулийн этгээдийн, иргэний, газрын, татварын зэрэг дийлэнх бүртгэлийн ажиллагаа электрон хэлбэрт орж эхэлж байгаа бөгөөд 2015 он гэхэд нийтийн албаны бичиг хэрэг бүхэлдээ цаасан биш электрон хэлбэрт шилжсэн байхаар зорьж байна.

Хуулийн этгээдийн болон төрсөн, нас барсан зэрэг бүртгэлийг иргэн аль нэг газар очин шаардлагагүй интернэтээр бүртгүүлж болох бөгөөд төрийн зүгээс мэдээллийн үнэн, баталгаатай байдлыг шалгахдаа нотариатыг ашиглаж байна. Тухайлбал, хуулийн этгээд нь бүртгүүлэхдээ хуульд заасан шаардлагыг хангах бөгөөд зөвшөөрөл хүссэн маягтад бөглөсөн мэдээллийн үнэн, зөв болохыг нотариатаар баталгаажуулсны дараа илгээж байна.

Тус улсын Засгийн газар 2003 оноос нийт улсыг хамарсан “цахим засаглал” бий болгохыг эрмэлзэж, тус харилцааг зохицуулах Цахим засаглалын хууль(E-government act), “Цахим Герман”(Deutschland Online) стратеги хөтөлбөр, Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн хууль болон бусад дагалдах олон тооны хууль, хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлж байна. Эдгээрээс “Цахим Герман” стратеги хөтөлбөр нь бүртгэлийн тогтолцоог сайжруулах, холбооны улсыг хамарсан нэгдсэн бүртгэлийн тогтолцоог бий болгохыг зорьсон.

Тус хөтөлбөрийг Холбооны Засгийн газраас 2003, 2006 онуудад тус тус баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөө байх ба жил бүр шинэчлэгддэг. Хөтөлбөрийн хүрээнд Авто тээврийн хэрэгслийн бүртгэл, Иргэний бүртгэл, Бүртгэлийн тогтолцоог хянах, сайжруулах гэсэн 3 төслийг хэрэгжүүлсэн. Төслүүдийн үр дүнд тээврийн хэрэгслийн бүртгэлийг бүрэн цахимжуулсан, мөн Бавариа, Дортмунд зэрэг зарим мужуудад иргэний бүртгэлийг цахимжуулсан, түүнчлэн “нэг цэгийн үйлчилгээний цэг” нэвтрүүлсэн бөгөөд одоогоор 220 гаруй ийм цэг ажиллаж, олон төрлийн бүртгэл, зөвшөөрөл олгох үйлчилгээг үзүүлж байна. Ингэж

цахимжуулснаар тухайн мэдээллийн өөрчлөлтүүд байнга шинэчлэгдэж, хуучрахгүй, бодит мэдээлэлд тулгуурлах давуу талтай болжээ.

Дээрх судалгаанаас дүгнэхэд Монгол Улсад хуулийн этгээдийн бүртгэл нь улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцооны үндсэн нэг төрөл болж, нарийвчилсан харилцааг тусгайлсан хуулиар зохицуулж байгаа нь олон улсын жишигт нийцэж байна. Хуулийн төсөлд хуулийн этгээдийн бүртгэлийн төрлийг дахин нягталж, практикт хийгддэг бүртгэлийн ажиллагаа нь иргэдэд хир хялбар дөхөм болохыг тодруулах нь чухал байна.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгахдаа шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, батлан гаргах хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үзэж байна.

Тус хуулиар дараахь асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Үүнд:

-Хуульд хэрэглэгдэж байгаа зарим нэр томъёог нэг мөр ойлгож хэрэгжүүлэх зорилгоор бусад хуультай уялдуулж холбогдох өөрчлөлтийг оруулах;

-Улсын бүртгэлд бүртгэх хуулийн этгээдийн төрлийг Иргэний хуульд нийцүүлж шинэчлэн тогтоох, хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах талаар нарийвчилсан зохицуулалтыг тусгах;

-Хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хүрээнд холбогдох зохицуулалтыг Компанийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Өрсөлдөөний тухай хуулиудын зүйл, заалтуудтай нийцүүлэх;

-Практикт эрх зүйн зохицуулалтгүй байдлаас үүсдэг маргааныг шийдвэрлэх хүрээнд зарим зохицуулалтыг шинээр оруулах;

-Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд тусгасан бүртгэлийн цахим үйлчилгээний талаарх дэвшилттэй зүйл, заалтуудыг хадгалж үлдэх;

-Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж хариуцлагын талаарх зохицуулалтыг тусгах зэрэг болно.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Хавсралт

1. Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага, хууль тогтоомжийн жагсаалт

Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага:

- Бүртгэлийн тогтолцоо: Сайн туршлага /Харьцуулсан судалгаа/, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2014 он
- Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2013 он
- Монгол Улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг /Олон улсын симпозиум/, Улсын Их Хурлын тамгын газар, 2016 он

Хууль тогтоомжийн жагсаалт

- Монгол Улсын Үндсэн хууль
- Иргэний хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль
- Компанийн тухай хууль
- Нөхөрлөлийн тухай хууль
- Хоршооны тухай хууль
- Төрийн бус байгууллагын тухай хууль
- Өрсөлдөөний тухай хууль
- Хөрөнгө оруулалтын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
- Улс төрийн намын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Цахим гарын үсгийн тухай хууль

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Улсын бүртгэл хийх талаар хуулийн этгээдэд тавигдах шаардлага, шалгуурыг нийтлэг, тэгшээр хуульчилна.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Улсын бүртгэл хийх талаар хуулийн этгээдэд тодорхой шалгуур тавьж, хязгаарлалт тогтоох боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Өрсөлдөөнийг шударга, хэрэглэгчдэд ээлтэй байх зарчимд тулгаарлан сөрөг үр дагаварыг буруулахад зохицуулалтын зорилго чиглэгдэнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Холбогдох хуулийн этгээд, үйлчилгээ хүртэгсэд болон улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байгаа улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтнуудаас ирүүлсэн саналыг үндэслэж хуулийн төслийг боловсруулна.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор тогтоосон хүний эрхийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдэнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хууль зөрчсөн, худал баримт бүрдүүлсэн зэрэг этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох

				хуульд заасны дагуу тооцно.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Шударга ёсонд нийцсэн шаардлагын үндсэн дээр хуулийн этгээдэд тодорхой хязгаарлалт тогтооно.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Энэхүү хязгаарлалт нь нийтийн эрх ашиг, аюулгүй байдлын үүднээс зайлшгүй шаардлагатай бөгөөд Үндсэн хуульд заасан зайлшгүй нөхцөлд хамаарна.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	• Хуулийн этгээд • Үйлчүүлэгч иргэд
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөлд ялгаж тодорхойлох шаардлагагүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөлд ялгаж тодорхойлох шаардлагагүй.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Хуулийн төсөлд ялгаж тодорхойлох шаардлагагүй.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Улсын бүртгэгч, хуулийн этгээд, иргэд улсын бүртгэл хийлгэх чиглэлээр үүрэг хүлээнэ.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах талаар бүртгэл хийлгэхэд тавигдах шалгуур, үйл ажиллагаа явуулах, хяналтын бүх нөхцөлд жендэрийн тэгш байдлыг бүрдүүлсэн.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хүснэгтийн 5.1-д заасан тайлбартай адил.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Дотоодын хуулийн этгээдийн чадавхийг нэмэгдүүлэх давхар зорилготой тул гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, түүний салбар, төлөөлөгчийн газарт илүү шаардлага тавигдана.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Дотоодын хуулийн этгээдийн чадавхийг нэмэгдүүлснээр зарим нэг нөлөөллөөс сэргийлж чадна.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж	Тийм	Үгүй	Нэмэлт зардал үүсэхгүй.

улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх			
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн этгээдүүд байгууллагдаж ажиллана.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсөвт ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй

байгууллага	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн дагуу зарим чиг үүрэг нэмэгдэх боловч дотоод зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн этгээд шинээр үүсэн байгуулагдах, өргөжихөд нөлөөлнө.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Улсын бүртгэлийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээ сайжирна.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын ачаалал хөнгөрч, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд эерэг нөлөө

	нөлөөлөх эсэх			үзүүлнэ.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч эерэг нөлөө гарна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үйлчилгээний хүртээмж, чанар сайжирснаар гэмт хэргийн гаралт буурч, эерэг нөлөө гарна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	сөрөг нөлөө үзүүлэх эсэх			
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх			
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

**Хуулийн этгээд, түүний улсын бүртгэлийн талаарх зохицуулалтыг
Монгол улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуулиудаас
түүвэрлэсэн судалгаа**

№	Хуулийн нэр	Холбогдох зүйл, заалт
1.	Иргэний хууль	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Хуулийн этгээд Нэгдүгээр дэд бүлэг Нийтлэг үндэслэл 25 дугаар зүйл. Хуулийн этгээд 25.1.Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ. 25.2.Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно. 25.3.Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна. 25.4.Хуульд өөрөөр заагаагүй бол хэд хэдэн хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа зохицуулах зорилгоор нэгдэж болох бөгөөд нэгдлийн оролцогчид хуулийн этгээдийн эрхээ хадгална. 25.5.Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно. 26 дугаар зүйл. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар 26.1.Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно. 26.2.Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах журмыг хуулиар тогтооно. 26.3.Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар хуульд заасан журмаар байгуулагдсанаар үүсч, татан буугдсанаар дуусгавар болох бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд бусад оролцогчтой адил тэгш эрхтэй оролцоно. 26.4.Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцоно. 26.5.Хуулийн этгээдийн удирдах байгууллагын эрх зүйн байдлыг хууль буюу үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно. 26.6.Ашгийн төлөө бус хуулийн этгээд өөрийн дүрэм болон үүсгэн байгуулсан бусад баримт бичигт заасан зорилгод нийцэх үйл ажиллагаа явуулна. 26.7.Ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй. 26.8.Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагааг эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс үүснэ. 26.9.Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварыг гагцхүү хуульд заасан үндэслэл, журмаар хязгаарлана. 27 дугаар зүйл. Хуулийн этгээдийн нэр 27.1.Хуулийн этгээд өөрийн нэртэй байна. Хуулийн этгээдийн нэр нь түүний зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан байна. 27.2.Хуульд заасан бол хуулийн этгээдийн төрлийг заасан нэртэй байна. 27.3.Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж

	болохгүй. 27.4. Хуулийн этгээдийн нэрийг бусад этгээд хууль бусаар ашиглахыг хориглоно. Энэ заалтыг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг энэ хуулийн 497 дугаар зүйлд заасан журмын дагуу арилгана. 27.5.Хуулийн этгээд нэрээ хуульд заасан журмын дагуу бүртгүүлнэ. 27.6.Хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалахад энэ хуулийн 21 дүгээр зүйлийн заалт нэгэн адил хамаарна. 28 дугаар зүйл. Хуулийн этгээдийн оршин байгаа газар 28.1.Хуулийн этгээдийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг түүний оршин байгаа газар гэнэ. 28.2.Хуулийн этгээд нь оршин байх нэг газар буюу хууль ёсны хаягтай байна. 29 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар 29.1.Хууль болон үүсгэн байгуулах баримт бичигт заасан бол хуулийн этгээд өөрийн салбар, төлөөлөгчийн газраа тогтоосон журмын дагуу байгуулж болно. 29.2.Хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу заримыг нь гүйцэтгэдэг тусгай нэгжийг салбар гэнэ. 29.3.Хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий нэгжийг төлөөлөгчийн газар гэнэ. 29.4.Салбар, төлөөлөгчийн газрын эрх, үүргийг тухайн хуулийн этгээдийн дүрмээр тодорхойлно. 29.5.Салбар, төлөөлөгчийн газрын эрх баригчид үйл ажиллагаагаа хуулийн этгээдээс олгосон итгэмжлэлийн үндсэн дээр явуулна. 29.6.Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар хуулийн этгээдийн эрхгүй байна. 30 дугаар зүйл. Хуулийн этгээдийг байгуулах 30.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг иргэн, хуулийн этгээд хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулж болно. 30.2.Чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар буюу хамтран хуулийн этгээд байгуулж болно. 31 дүгээр зүйл. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах 31.1.Хуулийн этгээдийн хөрөнгийг өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллага, түүнчлэн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно. 31.2.Хоёр буюу хэд хэдэн хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг нийлүүлэх гэнэ. 31.3.Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг нэгтгэх гэнэ. 31.4.Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг хуваах гэнэ. 31.5.Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг тусгаарлах гэнэ. 31.6.Хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар зохион байгуулагдаж болно. 32 дугаар зүйл. Хуулийн этгээдийг татан буулгах 32.1. Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг дараахь үндэслэлээр татан буулгана:
--	---

	32.1.1.өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллагын шийдвэр, түүнчлэн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэр гарсан; 32.1.2.дампурсанд тооцсон, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан; 32.1.3.үйл ажиллагаагаа явуулах хугацаа дууссан буюу зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан; 32.1.4.хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан; 32.1.5.хуульд заасан бусад үндэслэл. 32.2.Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилсон комисс эрхлэн гүйцэтгэнэ. 32.3.Татан буулгах комисс нь хуулийн этгээд татан буугдсан тухай нийтэд мэдээлнэ. 32.4.Татан буулгах комиссоос нэхэмжлэгчдийн өргөдөл хүлээн авах хугацаа нь хуулийн этгээдийг татан буугдсан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас багагүй, зургаан сараас ихгүй байна. 32.5. Хуульд өөрөөр заагаагүй бол татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг дараахь дарааллаар хангана: 32.5.1.бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөр ; 32.5.2.хэрэг гүйцэтгэгч буюу татан буулгах комисс, тэдгээртэй адилтгах бусад этгээдийн эрх, үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааны зардал; 32.5.3.дампурлын үед хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу гаргасан шаардлага; 32.5.4.хадгаламжийн албан журмын даатгалын нөхөн төлбөр; 32.5.5. хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгө; 32.5.6.хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдад төлөх хөдөлмөрийн хөлс; 32.5.7.хууль тогтоомжид заасны дагуу бусад этгээдтэй хийх тооцоо. 32.6.Татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг хангахдаа эхний дарааллын төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн дарааллын төлбөрийн шаардлагыг хангах зарчмыг баримтална. 32.7.Хуулийн этгээдэд байгаа мөнгөн хөрөнгө нь харилцагчдын шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол татан буулгах комисс түүний бусад эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу худалдаж, төлбөрийг барагдуулж болно. 32.8.Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол түүний эд хөрөнгийг төлбөл зохих төлбөрийн хэмжээнд хувь тэнцүүлэн зохих дарааллын дагуу харилцагчдад хуваарилна. 32.9.Харилцагчдын шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгчид, хууль буюу дүрэмд заасан бол эрх бүхий этгээдэд шилжүүлнэ. 32.10.Татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээж авах этгээд байхгүй бол төрийн өмчлөлд шилжүүлнэ. 32.11.Бүртгэх байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан тухай нийтэд мэдээлнэ. 32.12.Хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг татан буулгахад энэ зүйлийг баримтална. Хоёрдугаар дэд бүлэг Хуулийн этгээдийн төрөл 33 дугаар зүйл. Хуулийн этгээдийн төрөл
--	--

		33.1.Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна. 33.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна. 34 дүгээр зүйл. Компани 34.1.Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ. 34.2.Компанийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно. 35 дугаар зүйл. Нөхөрлөл 35.1.Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ. 35.2.Нөхөрлөлийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно. 36 дугаар зүйл. Холбоо, сан, хоршоо 36.1.Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ. 36.2.Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ. 36.3.Холбоо, сангийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно. 36.4.Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ. 36.5.Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна. 36.6.Сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаархи хуулийн заалтыг мөрдөнө. 37 дугаар зүйл. Сангийн тусгай зохицуулалт 37.1.Сангийн эрх барих байгууллага буюу удирдах зөвлөл нь хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ. 37.2.Сангийн эрх барих байгууллага нь гүйцэтгэх удирдлага болон хяналтын байгууллагыг томилно. 37.3.Сангийн гүйцэтгэх удирдлага сангийн дүрэмд нийцсэн үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг эрх барих байгууллагаараа хэлэлцүүлэн хэвлүүлж, олон нийтэд түгээнэ. 38 дугаар зүйл. Санг татан буулгах журам 38.1.Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилогдсон татан буулгах комисс эрхлэнэ. Онцгой тохиолдолд шүүхээс татан буулгах өөр байгууллага томилж болох бөгөөд тэрээр татан буулгах комиссийн гишүүдийн нэгэн адил хариуцлага хүлээнэ. 38.2.Санг татан буулгахдаа өдөр тутмын ажил хэргийг зогсоож, бэлэн байгаа эд хөрөнгийг мөнгөөр үнэлэн тодорхойлж, харилцагчидтай тооцоо хийнэ. 38.3.Энэ хуулийн 38.1-д заасны дагуу тооцоо хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг татан буугдсан сантай зорилго нэг буюу ижил төстэй зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн этгээдэд шилжүүлэх, тийм байгууллага байхгүй тохиолдолд төрийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргаж болно.
2.	ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	1 дүгээр зүйл. Хуулийн зорилго 1.1.Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар

		хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оршино.
3.	УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬ	5.4.Хуулийн этгээдийн улсын бүртгэл дараахь төрөлтэй байна: 5.4.1.хуулийн этгээдийн нэр, төрөл, хэлбэр; 5.4.2.хуулийн этгээдийг байгуулсан тухай /шинээр, эсхүл өөрчлөн байгуулсан/; 5.4.3.хуулийн этгээдийг үүсгэн байгуулагчийн болон үүсгэн байгуулах баримт бичиг, түүнд орсон өөрчлөлтийн; 5.4.4.хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох тухай /өөрчлөн байгуулах, татан буулгах/; 5.4.5.өөрчлөн байгуулах замаар шинээр үүссэн болон үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээд тус бүрийн эрх залгамжлалын; 5.4.6.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаарын; 5.4.7.хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн; 5.4.8.тухайн хуулийн этгээд салбар, төлөөлөгчийн газартай бол түүний оршин байгаа газрын хууль ёсны хаягийн; 5.4.9.компани бол түүний хувьцааг эзэмшиж байгаа этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, хаяг, эзэмшиж байгаа хувьцааны хэмжээ, түүнд орсон өөрчлөлтийн; 5.4.10.компанийн хувьд үүсгэн байгуулах баримт бичигт заасан өөрийн хөрөнгийн хэмжээний; 5.4.11.хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтны овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, албан тушаал, иргэний үнэмлэх, бичиг баримт болон татвар төлөгчийн бүртгэлийн дугаар;
4.	КОМПАНИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	1.1.Энэ хуулийн зорилт нь компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 2 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 2.1.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх компани өмчийн хэлбэр, эд хөрөнгийн болон үйлдвэрлэлийн хэмжээ, дотоод зохион байгуулалтаас үл хамааран энэ хуулийг дагаж мөрдөнө.
5.	НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь нөхөрлөлийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, тэдгээрийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, бүртгэл, тайлан гаргах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
6.	ХОРШООНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1. Энэ хуулийн зорилт нь хоршооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршооны тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
7.	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрхийг хэрэгжүүлэх зорилгоор иргэд эвлэлдэн нэгдэх, төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулах болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
8.	ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	8.1.Давамгайл байдалтай хуулийн этгээд бусад этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, эсхүл ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг өрсөлдөгч компанийн энгийн хувьцааны 20-оос дээш, давуу эрхийн хувьцааны 15-аас дээш хувийг худалдан авах, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдтэй нэгдэх, нийлэх тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт өргөдөл гаргана.
9.	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ	21.1.Дараах салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл

	/Шинэчилсэн найруулга/	авна: 21.1.1.уул уурхай; 21.1.2.банк, санхүү; 21.1.3.хэвлэл, мэдээлэл, харилцаа холбоо.
10.	УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	3 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамж 3.1.Төрийн эрх бүхий байгууллагаас энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж /цаашид “тэмдэгтийн хураамж” гэх/ гэнэ. 15 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээнд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ 15.1.Хуулийн этгээдийн эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагаанд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: 15.1.1.хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд 44 000 төгрөг; 15.1.2.хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэхэд 20 000 төгрөг; 15.1.3.хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд 10 000 төгрөг; 15.1.4.улсын бүртгэлийн мэдээллээс лавлагаа олгоход 5 000 төгрөг.
11.	ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн алба /цаашид "төрийн алба" гэх/-ны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавих шаардлага, төрийн алба хаах болзол, журам, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, баталгаа, төрийн албаны төв байгууллагын чиг үүргийг тогтоон зохицуулахад оршино.
12.	ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино.
13.	УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор улс төрийн нам /цаашид “нам” гэх/ байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох, тараах, улсын бүртгэлд бүртгэх, намын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, үүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. 9 дүгээр зүйл.Намыг улсын бүртгэлд бүртгэх 9.1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн1 15.1-д заасны дагуу тухайн нам үүсгэн байгуулагдсан өдрөөсөө хойш ажлын 10 хоногт багтаан бүртгэх байгууллагаас баталсан маягтын дагуу бүртгүүлэх өргөдлөө Улсын дээд шүүхэд гаргана. 9.2.Бүртгүүлэх өргөдөлд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15.2-т заасан мэдээллийг тусгана. 9.3.Нам нь Улсын дээд шүүхэд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 17.1-д зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ: 9.3.1.намыг бүртгүүлэхийг хүссэн намын даргын гарын үсэг бүхий өргөдөл; 9.3.2.намын нэр, бэлгэдэл, далбаа; 9.3.3.намын дүрэм; 9.3.4.намын мөрийн хөтөлбөр; 9.3.5.намын гүйцэтгэх байгууллага байнга оршин байгаа хууль ёсны хаяг; 9.3.7.намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг/;

		9.3.8.намын санхүүгийн асуудал эрхэлсэн эрх бүхий удирдах ажилтан /менежер, ерөнхий нягтлан бодох/-ны бүртгэл /овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэх болон регистрийн дугаар, оршин суугаа газрын болон гэрийн хаяг, гарын үсэг/ 9.3.9.намын хөрөнгийн мэдээ; 9.3.10.хуульд заасан бусад баримт бичиг.
14.	ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 5 дугаар зүйл.Цахим гарын үсгийг хэрэглэх 5.1.Хуульд өөрөөр заагаагүй бол цахим гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адил хэрэглэнэ.